

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

БАРИМТ БИЧИГ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН РЕФЕРАТ

MNS 5371 : 2004

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ

ТӨВ УЛААНБААТАР ХОТ

2004 ОН

MNS 5371 : 2004

Өмнөх үг

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (цаашид СХҮТ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг юм.

Тус Төв нь тухайн салбарын улсын стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөл (СХҮЗ)-ийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг эрдэм шинжилгээний ажлын тайлангийн мэдээллийн баазыг байгуулахтай холбогдон, реферат бичилт, бусад хайлтын элементүүдийг жигдрүүлэх зорилгоор Шинжлэх Ухааны Академи, Санхүү Эдийн Засгийн Яамны харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн Шинжлэх ухаан судлал төслийн удирдагч, доктор Н.Хүүхэнжимээгийн удирдлага доор Улсын төв номын сангийн хэлтсийн

дарга Д.Энхтунгалаг, Мэдээллийн технологийн үндэсний паркийн Шинжлэх ухаан технологи, мэдээллийн хэлтсийн ажилтан Н.Баясгалан, СХҮТ-ийн стандартын шинжээч Г.Батцэнгэл нар боловсрууллаа.

Энэ стандартыг ТХ/25 Баримт бичгийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн мэргэжлийн хувьд зөвшилцөлд хүрсэн тул, СХҮЗ-ийн хуралдаанаар батлуулсан болно.

Анхны үзлэгийг 2009 онд, дараа нь 5 жил тутамд хийнэ.

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв (СХҮТ) :

Энх тайвны өргөн чөлөө 46А
Улаанбаатар –211051. Ш/Х-48
Утас 451810, 457765
Факс (976-1) 458032
E-mail : masm@mongol.net
□ СХҮТ 2004

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХҮТ (Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага)-д байна.

ii

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.140.40

Эрдэм шинжилгээний тайлангийн реферат Abstracts for research record	MNS 5371 : 2004
--	------------------------

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2004 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 26 тоот тогтоолоор батлав.

2004 оны 08 дугаар сарын 01-нээс эхлэн хүчинтэй

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь эрдэм шинжилгээний ажлын тайлангийн реферат бичихэд тавих шаардлагыг тогтооно.

Шинжлэх ухааны бусад бүтээл, туурвилд ашиглаж болно.

2 Норматив ишлэл

1) *ISO 214 Documentation. Abstracts for publications and documentation.*

3 Агуулгын бүтэц шаардлага

3.1 Реферат нь тухай тайлангийн агуулгын хураангуй болно. Бие даасан тайлан бүрт реферат бичнэ.

3.2 Реферат тухайн тайлангийн агуулгын талаар хамгийн их мэдээллийг багтаана. Реферат нь тайланг мэдээллийн хувьд бүрэн төлөөлөхгүй. Рефератыг нарийн мэргэжлийн эрдэмтэн, судлаач хүнд хангалттай сайн мэдээллийг (ойлголтыг) өгч чадахуйцаар бичнэ.

3.3 Рефератад тухайн тайлангийн зорилго, судалгааны арга, **үр дүн, дүгнэлтийн талаар товч, тодорхой, хураангуй мэдээллийг** багтаана.

3.4 Рефератад тайлангийн нэрийг бичихгүй, “Реферат” гэсэн гарчигтай байна. Рефератыг тэрхүү тайланд зориулж бичсэн тайлбар, реценз, санал, дүгнэлтээр төлөөлүүлж болохгүй.

3.5 Реферат нь дараахь логик бүтэцтэй байна. Үүнд:

- **Зорилго.** Энд тухайн эрдэм шинжилгээний ажлын зорилго, шаардлага, үндэслэлийг гаргаж өгнө.
- **Судалгааны арга.** Тухайн эрдэм шинжилгээний ажлын аргачлал, туршилт уг ажлыг гүйцэтгэсэн онцлог, нөхцөл байдал, үндэслэлийн тухай товч бичнэ.
- **Үр дүн, шинэлэг зүйл.** Судалгаа, туршилтын явцад гаргасан гол үр дүнг (мөн хаана нэвтрүүлэх, ямар үр ашиг гарах зэргийг) тоо, баримттайгаар, зөвхөн тоочих байдлаар бичнэ.

MNS 5371 : 2004

• **Дүгнэлт.** Гол дүгнэлт, саналыг товч, хураангуй бичнэ. Тайлбаргүйгээр жагсаана.

Рефератыг тайлангаас тусгайд нь нийтлэх тохиолдолд энэ дөрвөн зүйл дээр “Тайлангийн номзүй”, “Нэмэлт мэдээлэл” хоёрыг нэмэх шаардлагатай.

• **Тайлангийн номзүй:** Тайлангийн нэр, удирдагч, гүйцэтгэгчид (олон гүйцэтгэгчдийг эхний 2-3 эрдэмтэн судлаачийн овог, нэр, албан тушаалтай нь бичиж “... ба бусад” гэж товчилно), гүйцэтгэсэн байгууллага, он, тайлангийн боть, нийт хуудасны тоог заана.

• **Нэмэлт мэдээлэл:** Энэ нь тус тайлангийн эшлэлийн тоо, хавсралт зураг, ном, нууцын зэрэглэл, бусад өөр тайлбар, тодорхойлолт байж болно. Зохиогч өөрөө рефератыг бичээгүй тохиолдолд тайлангийн дотор ажиглагдсан утгын болон техник алдааны тухай реферат бичигч нэмэлт мэдээлэлд товч оруулж тэмдэглэхийг зөвшөөрнө.

3.6 Рефератын бичвэрт агуулгын хувьд энэхүү стандартын 3.5-д заасан дарааллыг баримтална.

Хэрэв 3.5-д заасан логик бүрэлдэхүүний аль нэг нь тайлангаас томъёологдохгүй тохиолдолд энэ тухай онцгойлон дурьдах шаардлагагүй.

3.7 Рефератад зураг, схем, томъёо, хүснэгтийг оруулахыг зөвхөн онцгой тохиолдолд зөвшөөрнө.

3.8 Рефератыг товч, тодорхой үг хэллэгтэй, албаны буюу лавлагааны найруулгатай бичнэ. Элдэв тайлбар, нуршаа үг, өгүүлбэрийг (Жишээ: Ихээхэн ач холбогдолтой юм, зохиогчийн үзэж байгаагаар, туйлын чухал зүйл мөн гэх мэт хүч нэмэгдүүлсэн, тайлбарласан илэрхийллийг) хэрэглэхийг хориглоно.

3.9 Рефератыг тухайн тайлангийн хэлээр бичнэ. Шаардлагатай тохиолдолд рефератыг англи, орос хэлээр бичиж тайланд дагалдуулахыг зөвшөөрнө.

3.10 Рефератад шинжлэх ухааны нийтлэлд өргөн хэрэглэгддэг илэрхийлэл, нэр томъёо, өгүүлбэр, нэгж, товчлолыг ашиглана. Тайланд олон удаа давтагдсан нэр томъёо, ойлголтын товчлолыг рефератад ашиглахдаа тэдгээрийг уг товчлолын тайлбар болгон нэг удаа бичнэ. Зарим илэрхий ойлгомжтой үгийг товчилж болно.

3.11 Рефератын хэмжээ 250-500 үгээс хэтрэхгүй байна. Дэлгэрэнгүй тайлангийн хувьд (Жишээ: нийгмийн ухааны салбарын) 1000-1500 үг байж болно.

3.12 Рефератыг тайлангийн гүйцэтгэгч өөрөө зохион бичихийг зөвлөнө. Реферат бичих ажлыг тайланг системчлэн бичиж боловсруулахтай адил хариуцлагатай зүйл гэж ойлговол зохино.

ТӨГСӨВ.